



Method of human education in Buddhist philosophy

Gantuya Pagvajav

Article information

Article history:

Received: 2024.11.05

Revised: 2024.11.13

Accepted: 2024.11.20

Keywords:

Monastery

Temple

Congregation

Church

Choir datsang

Manba datsang, Astrology datsang

Jud datsang

ABSTRACT

We Mongolians have a great heritage of ancient civilization, intellectual and religious traditions, and Buddhism is one of the main foundations of the intellectual harmony of Mongolian civilization. The religion of Buddhism spread in Mongolia has left us a huge heritage of culture, art and ethics. Buddhist teachings are the teachings of the purification of the mind and a wealth of knowledge for the development of the mind. Buddhism brings awareness to the nature of the world, purifies the soul, develops human inner abilities through more or less five senses, and leads to a profound and higher level of thinking.

Corresponding author:

Gantuya Pagvajav

Mandakh University

Email: p.ganaa0812@gmail.com

Буддын шашны философи дахь хүнийг хүмүүжүүлэх арга ухаан

Пагважавын Гантуяа

Санал болгож буй эшлэл:

Гантуяа, П. (2024). Буддын шашны философи дахь хүнийг хүмүүжүүлэх арга ухаан. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл, Тусгай дугаар*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.10>

To cite this article:

Gantuya, Pagvajav. (2024). Method of human education in buddhist philosophy. *Mongolian Journal of Educational Research, Special Issue*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.10>

БУДДЫН ШАШНЫ ФИЛОСОФИ ДАХЬ ХҮНИЙГ ХҮМҮҮЖҮҮЛЭХ АРГА УХААН

ОРШИЛ

Монголд дэлгэрсэн Бурханы шашин нь соёл урлаг шинжлэх ухаан, ёс зүйн асар том цар хүрээтэй өв уламжлалыг бидэнд үлдээсэн юм. Бурханы шашин нь сургалтын өвөрмөц тогтолцоотой байсан бөгөөд Монголд түгэн дэлгэрэхдээ монгол эрдэмтдийн зохиол бүтээлээр баяжигдан өөрийн гэсэн өвөрмөц дэг жаягтай болсон байна. Монгол дахь сүм хийдүүд нь тодорхой сургалтын үр дүнд шашны мэргэжилтнүүдийг бэлтгэж иржээ. Шашны сургалт нь өөрийн гэсэн дэг жаягтай байсан бөгөөд тухайн соёл боловсролыг түгээх төв нь байлаа.

Онолын судалгаа: Анхдугаар богд Жавзандамба хутагт Өндөр гэгээн Занабазар 1647 онд “Шанхын баруун хүрээг” байгуулсан нь дацангийн сургалтын бага боловсролын тогтолцоо үүссэн эхлэл юм. Шашны бага боловсрол гэдэг нь хурлын уншлага зан үйлд боловсрох үе бөгөөд үүнд их уншлага, бага уншлага нь цогчин (харанга магтаал), 100 гаруй төрлийн номыг сурч судалдаг. Хурлын уншлагын эрдэмд боловсроно гэдэг нь шашны бага боловсрол юм.

Халхын Их хүрээний номч гавж Лувсандаяны туурвисан “Хор чойнжунг”/ᠬᠣᠷ ᠴᠣᠶᠢᠨᠵᠢᠩ/ шаштир болон Сэцэн ханы Нанзад агримбын “Данзий” тэргүүтэн зохиолуудад халхын анхны чойрыг төмөр хонин жил 1751 онд Сэцэн ханы хүрээнд Өөлдийн цорж Тавхайринчин байгуулсан гэж тэмдэглэсэн байдаг. Энэ нь цанид чойрын дацангийн үүсэл буюу Монголд 1751 онд Монголын шашны сургалтын дунд болон дээд боловсролын тогтолцоо үүссэн байна. Дацангийн судлагдахууны хүрээнд багтан заавал судлах ухаануудыг хоёр үндсэн оронд хуваан авч үздэг ажээ. Үүнд:

Ухааны их таван орон:

1. Дотоод ухаан -/ᠳᠣᠲᠤᠨ ᠤᠬᠠᠭᠠᠨ /
2. Учир шалтгааны ухаан- /ᠤᠴᠢᠷ ᠰᠠᠯᠲᠦᠭᠠᠨᠢ ᠤᠬᠠᠭᠠᠨ /
3. Дуун ухаан /хэл шинжлэл/- /ᠳᠤᠭᠤᠨ ᠤᠬᠠᠭᠠᠨ /
4. Урлахуйн ухаан- /ᠤᠷᠯᠠᠬᠤᠢᠨ ᠤᠬᠠᠭᠠᠨ /
5. Тэжээхүйн ухаан - /ᠲᠡᠵᠡᠭᠡᠬᠦᠢᠨ ᠤᠬᠠᠭᠠᠨ /

Ухааны бага таван орон нь:

1. Зурхай - /ᠵᠤᠷᠬᠠᠢ /
2. Яруу найраг - /ᠶᠠᠷᠤᠨᠨᠠᠶᠢᠷᠠᠭ /
3. Илт өгүүлэхүйн ухаан - /ᠢᠯᠲᠦ ᠥᠭᠦᠯᠡᠬᠦᠢᠨ ᠤᠬᠠᠭᠠᠨ /
4. Холбон найруулахуйн ухаан - /ᠬᠣᠯᠪᠣᠨᠨᠠᠶᠢᠷᠤᠯᠠᠬᠤᠢᠨ ᠤᠬᠠᠭᠠᠨ /
5. Жүжгийн ухаан орно - /ᠵᠦᠵᠦᠭᠢᠨ ᠤᠬᠠᠭᠠᠨ ᠣᠷᠨᠤ / (Дагвадорж, 2000)

Гүн ухааны мэргэжлийн сургалт 5 шатлалтайгаар явагддаг бөгөөд гүн ухааны үндсэн 5 боть судрыг судалдаг байжээ. Энэ нь:

- ✓ Намдэл- /ᠨᠠᠮᠳᠡᠯ / гүн ухааны логик буюу учир шалтгааны ухаан юм. Судлаачдын зарим нь “цадма”, зарим нь “дүйрээ” гэж томъёолжээ. Логик нь зөв сэтгэхүйн хэлбэр, дүрэм зарчмуудын тухай шинжлэх ухаан юм. Логикийн ухааныг боловсруулахад дорно дахины сэтгэгчид ялангуяа Араб, Энэтхэгийн мэргэд ихээхэн анхаарч байсан баримтууд бий. Буддын философийн төлөөлөгчид Дигнага, Дхармакирта, Васубанду, Нагаржуна нарын бүтээлүүдэд логик танин мэдэхүйн онолын үзэл баримтлалуудыг боловсруулсан байдаг.
- ✓ Парчин- /ᠫᠠᠷᠴᠢᠨ / Бурханы гэгээрэхүй буюу билгийн чанад хүрэхийн ухаан. Тодруулбал, төгс гэгээрэх сэтгэлгээний үе шатуудын тухай сургаал юм.
- ✓ Ума- /ᠤᠮᠠ / гүн ухааны хамгийн нарийн ойлголт болох хоосон чанарын онол. Ума нь логика /учир шалтгааны ухаан/, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүй, илтгэх урлагт мэргэжүүлэх сургалт юм. Учир шалтгааны ухаан нь дотроо ангилагдан анги дэвших бүрт гүнзгийрэн судалдаг байжээ.

- ✓ Авидарма- /ᠠᠪᠢᠳᠠᠷᠮᠠ/ буюу Зодын гүн ухаан бодьсадын сэтгэл үүсгэж сэтгэлийн хатуужил суун хоосон чанарыг олох ёс юм.
- ✓ Дулба - /ᠳᠤᠯᠪᠠ/ буюу Винай-сахил санваарын 253 ёсны номлолыг судалдаг.

Дацангийн сургалтад 5-8 насны хөвгүүдийг боловсролын өндөр зэрэгтэй лам багшид шавь оруулж 1-3 жилийн хугацаанд ганцаарчилсан сургалтад хамруулдаг байсан байна. Хүссэн хүүхэд бүр лам багшид шавь орох боломжгүй бөгөөд шавийг шинжин үзэж сонгон авдаг байсан. Гэрийн багшаар төвд хэл заалган, залбирал, ерөөл, магтаал зэрэг хурлын уншлага унших анхан шатны мэдлэгтэй болдог бөгөөд төвд хэл бичигт тайлагдан хурлын уншлагатай болсноор сүм хийдэд шавилан суух эрхтэй болдог. 10-15 насны орчим чойр цанидын гол уншлага, тухайлан “Илт онолын чимэг”, “Дундад орохуй”, “Илт номын сан” хэмээх билиг барамид, төв үзэл, абхидхармын зава буюу үндсэн гол номуудыг бүрэн цээжилдэг. Цээжилж тогтоосноо шалгуулснаар цаашид цанид чойрын дацанд суралцах эрхийг олж аван, Буддын гүн ухааныг эрэмбэ дараатай үзэж эхэлдэг байв. Ном эрдэмд шамдан суралцахад өдрийн дэглэм маш чухал. Өглөө эртлэн босож залбирал үйлдээд хурлын уншлагад оролцоно. Үдээс өмнө багшаараа номоо хөтлүүлж заалгана. Үд дунд заалгасан номоо зиндааныхантайгаа хэлэлцэнэ. Оройдоо хичээлээ дахин давтаж, зиндааны нөхөдтэйгээ дагсал буюу ном хаялцан, мэтгэлцэх журмаар судалж буй номынхоо гүнд нэвтэрч дадлагажина. Бурханы шашны дацангийн сургалтын агуулга нь хүмүүсийн мэдлэгийн хэр хэмжээ, оюуны чадамж нас зэрэгт нь тохируулан энгийнээс гүн нарийн сургаалийг танин мэдэж суралцахад чиглэдэг. Бурханы шашинд гүн нэвтэрч эрдэм ухаан сайтар эзэмшихийн чухал суурь нь багшийг шүтэх ёс юм (Лувсанцэрэн, Г., Ариунаа, Э. 2014).

Багшийг шүтэх ёс нь лам хуврагууд төдийгүй эгэл хүмүүст багштай хүн бүрд хамаарах юм. Аливаа шавь савын гурван гэмийг тэвчин зургаан хуран мэдлийг шүтэх ёстой хэмээн Богд Зонхава айлдсан байдаг. Багшийн заасан номыг анхаардаггүй, анхаарсан ч буруу үзлээр хүлээн авдаг, тухайн үедээ анхаараад хүлээж авсан мэт боловч төдөлгүй мартдаг гэсэн гурван гэмийг хөмөрсөн сав, бохир сав, цоорхой савтай зүйрлэн ном сонсогч нь чин шударга, оюун саруул, нэн хичээнгүй байх ёстойг сургасан байдаг. Гавж Т.Дамдинсүрэн хүүхдийг шавилан сууснаас хойш нэг жилийн дараа номд ухаан орсон хойно сэтгэлийг нь тогтоох ном заадаг байсан. Сэтгэл тогтоно гэдэг бол аливааг бодох бололцоотой болно гэсэн үг. Арга, билэг гэж бий. Сэтгэл тогтоох гэдэг бол арга юм хэмээн тодорхойлсон байдаг. Төвд үсэг бичигт тайлагдсаных нь дараа тусгай сургалтад хамруулан суралцах арга ухаан заадаг байсан байна. Ийнхүү сэтгэлийг нь тогтоосны дараагаар ухаан задлах ном үздэг байжээ. Т.Дамдинсүрэн гавжийн тайлбарласнаар ухаан буюу шийрэв нь билэг болох учиртай ажээ. Ийнхүү сэтгэл тогтсон шавийг ухаан задлах номын буюу дараагийн сургалтын шатанд дэвшүүлдэг байжээ. Энэ нь дацангийн анхан шат буюу “хадаг зиндаанд” орж суралцах эрх нээгдэнэ гэсэн үг ажээ.

Хүснэгт 1. Шашны сургалтын анги зиндаа, судлагдахуун

№	Анги зиндаа	Судлагдахуун	Тайлбар
1	Хадаг зиндаа ᠬᠠᠳᠠᠭ	Намдэл	Чойрын гүн ухааны 5 ботийн эхний боть Намдэл ботийг хадаг, шидэв, жумбурай, юлжин, дондонжуу зиндаанд судладаг. Намдэл- /ᠨᠠᠮᠳᠡᠯ/ нь гүн ухааны логик буюу учир шалтгааны ухаан “юм. Судлаачдын зарим нь “Цадма”, зарим нь “Дүйрээ” гэж томъёолжээ. Логик нь “Зөв сэтгэхүйн хэлбэр, дүрэм зарчмуудын тухай шинжлэх ухаан” юм.
2	Шидэв зиндаа ᠰᠢᠳᠡᠪ	Намдэл	
3	Жумбурай зиндаа ᠵᠤᠮᠪᠤᠷᠠᠢ	Дагриг	
4	Юлжин зиндаа ᠶᠤᠯᠵᠢᠨ	Логриг	
5	Дондонжуу зиндаа ᠳᠣᠨᠳᠣᠨᠵᠠᠭᠤ	Салам, Дүнта Дондогжуу	
6	Шун ог зиндаа ᠰᠤᠨᠣᠭ	Парчин	
7	Гом зиндаа ᠭᠣᠮ	Парчин	
8	Габдамба зиндаа ᠭᠠᠪᠳᠠᠮᠪᠠ	Парчин	
9	Дом зиндаа ᠳᠣᠮ	Парчин	

10	Умасарба зиндаа ᠤᠮᠤᠰᠢᠷᠪᠠ	Ума	Умасарба, уманинба зиндаанд Чойрын гүн ухааны 5 ботийн 3 дахь боть “Ума”-г судладаг. Ума- ᠤᠮᠠ гүн ухааны хамгийн нарийн ойлголт болох хоосон чанарын онол. Ума нь логика /учир шалтгааны ухаан/, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүй, риторика /илтгэх урлаг/-г мэргэжүүлэх сургалт юм.
11	Уманинба зиндаа ᠤᠮᠠᠨᠢᠨᠪᠠ	Ума	
12	Зод зиндаа, ᠵᠣᠳ	Авидарма	Зод, гаарамба ог зиндаанд Чойрын гүн ухааны 5 ботийн 4 дэхь боть “Авидарма”-г судладаг. Авидарма- ᠠᠪᠢᠳᠠᠷᠮᠠ буюу Зодын гүн ухаан бодьсадын сэтгэл үүсгэж сэтгэлийн хатуужил суун хоосон чанарыг олох ёс юм.
13	Гаарамба ог зиндаа ᠭᠠᠶᠠᠷᠠᠮᠪᠠ	Авидарма	
14	Гаарамба сарва зиндаа ᠭᠠᠶᠠᠷᠠᠮᠪᠠ	Дулба	Гаарамба сарва, их гаарамба зиндаанд Чойрын гүн ухааны 5 ботийн 5 дахь боть “Дулба”-г судладаг. Дулба - ᠳᠤᠯᠪᠠ нь Винай-сахил санваарын 253 ёсны номлолыг судладаг.
15	Их гаарамба зиндаа ᠶᠡᠬᠡᠭᠠᠶᠠᠷᠠᠮᠪᠠ	Дулба	

Хүснэгт 2. Шашны сургалтын бүтэц

Мэргэжлийн чиглэл		Суралцах дамжаа	Судлагдахуун	Зэрэг цол	Суралцаж дамжаа барих дацан	Суралцах хугацаа
Дотоод ухаан	Судрын буюу чойрын гүн ухаан	Домын дамжаа	Чойрын гүн ухааны 5 боть номын эхний 2 боть ном Намдэл, Парчинг судладаг.	Гэвш	Дашчоймпэл дацан Гунгаачойлин дацан Идгаачойнзинлин дацан Гэвшийн дамжаа барьдаг хүрээ хийдүүд	4-5 жил
		Гаарамбын дамжаа	Чойрын гүн ухааны 5 ботийн 3 дахь боть Ума, 4 дэхь боть Авидарма, 5 дахь боть Дулбаг судладаг.	Гавж	Дашчоймпэл дацан Гунгаачойлин дацан Идгаачойнзинлин дацан Гавжийн дамжаа барьдаг хүрээ хийдүүд	4-14 жил
				Равжимба	Төвдийн Гүмбөм дацан	4-14 жил
				Доримба	Төвдийн Ловрон, Дашлхүмбэ дацан	4-14 жил
Лхаримба	Төвдийн Сэмбэрэгэсүм	4-14 жил				
Зурхайн ухаан	Одон зурхай	Зурхайн дацан	Зурхай, тооны ухаан ба астрономийн зохиолууд	Зурхайч	Зурхайн дацан	4-14 жил
		Зийрамбын дамжаа		Зийримба		
Тэжээхүйн ухаан	Анагаах ухаан	Манба дацан	Анагаах ухаан ба эм зүй	Эмч, домч	Манба дацан	4-14 жил
		Манрамбын дамжаа		Манримба		
Агь тарни	Агь тарнийн ухаан	Аграмбын дамжаа	Агь тарни	Агримба	Жүд дацан	10 жил

Монголд хөгжиж байсан дацангийн сургалтын систем нь Энэтхэг, Төвдөөс уламжлагдсан бөгөөд Монгол эрдэмтэн лам нарын мэдлэг ухаанаар баяжигдан өөрийн гэсэн өвөрмөц тогтолцоог бий болгожээ. Монголын хүрээ хийд дацангийн сургалт нь дараах ач холбогдолтой байсан. Үүнд :

- Монголчуудын оюун ухаан, ёс суртахуун, соёл, зан заншил, хүмүүний зан араншин, үйл үйлдэл, биеэ авч явах ёсон гээд л бүхий л талаар төлөвшүүлэн хөгжүүлэх сургалтын арга ухаан,
- Энх тайван, амгалан тайван амьдрах, бүхий л оршихуйг хайрлах, багш шавийн ёс, ах дүүсийн хүндлэл, аливаа хүнийг ялгаварлан үзэхгүй байх цогц үндэс, арван хар нүгэл, арван цагаан буяны ойлголтоор дамжуулах сургаал, сургалтууд,
- Өнөө үед туйлын чухал ногоон хөгжил, цаг уурын дулаарал, агаарын бохирдол, байгаль дэлхийгээ хайрлах шүтэх хамгаалах ёсон,
- Орчин үеийн одон орон, тоон зурхайн ухааны харилцан шүтэлцээ, мал аж ахуй, газар тариалан, бусад хүмүүний амьдралд тэдний нөлөөлөх нөлөөллийг зөв ойлгож, ашиглах арга ухаан

- Буддын гүн ухаанд өөрийн муу сэтгэл буюу нисванисыг хэрхэн дарах, байгаа зүйлдээ сэтгэл хангалуун байх арга ухаан, тэсвэр тэвчээртэй туйлбартай байх арга ухаан,
- Хүн, байгалийн хөгжлийн тухай гүн ухаан, номлолыг сургах арга ухаан,
- Сүм хийд, дацангийн уран барилгын соёл зэрэг нь өнөөгийн зах зээл, аялал жуулчлалын эрин үед нэн ач холбогдолтой байгаа билээ.

ДҮГНЭЛТ

Бурханы шашны дацангийн сургалтаар дамжуулан хүмүүнлэг энэрэнгүй бодь сэтгэлтэй иргэнийг хүмүүжүүлэх гол зорилготой бөгөөд орчлон хорвоогийн бүхий л оршихуйг хайрлан энэрэх бодь сэтгэлийг бий болгох боломжтойг сургадаг. Бурханы шашин нь ёс зүйн төгс төгөлдөр байдлын төлөө практикийн болон онолын мэдлэг сургааль юм. Монгол оронд гурвантаа дэлгэрэн хөгжиж ирсэн Бурханы шашны дацан сургуулиуд нь тухайн үедээ соёл боловсрол, шинжлэх ухааны төв болж, Бурханы шашин нь соёл, урлаг, анагаах ухаан, зурхай, боловсролын зэрэг олон салбарыг өөртөө багтаан хөгжиж иржээ. Түүгээр ч үл барам эдгээр төвүүдээс олон арав, зуун эрдэм номтой шашны томоохон төлөөлөгчид төрөн гарч, зохиол бүтээлээ туурвин, Монголын уламжлалт боловсролын хөгжлийн нэгэн үеийн түүх болон үлджээ. Дацангийн сургалт нь чойрын гүн ухаан, тэжээхүйн ухаан буюу анагаах ухаан, зурхайн ухаан гэсэн үндсэн 4 чиглэлээр хөгжиж байсан бөгөөд эдгээр дөрвөн чиглэл нь шинжлэх ухааны бусад чиглэлийг зэрэгцүүлэн хөгжүүлэх гол түлхэц нь болж байжээ. Дацангийн сургалтын судлагдахуун нь тогтсон тодорхой системтэй байсан ажээ. Лам болох шавь багшид шавь орсоноос эхлэн бэлтгэл 1-3 жил, доод зиндаа 5 жил, дунд зиндаа 4 жил, ахлах зиндаа 4-5 жил, гаарамбын дамжаа 4-14 жил агримбын дамжаа 10 жил нийт 39-41 жил суралцдаг байжээ. Сургалт эрхэлдэг, эрдмийн зэрэг цол олгодог дацангууд нь Бурханы шашны боловсролыг олгож, эрдэм мэдлэгтэй лам хуврагуудыг бэлтгэн гаргадаг байжээ. Буддын гүн ухааныг чойрын дацанд гэвш болсон лам нар цааш гүнзгийрүүлэн судлах боловч, зарим нэг нь тэжээхүйн ухааныг судлах манба дацан, тарнийн ёсыг судлах жүд дацан, тантарын сургаалыг судлах дүйнхор дацан, цаг улирал мэргэ төлгийн зүйл судлах зурхайн дацангуудад өөрийн сонгосон чиглэлээр шат дараалан ном үзэж эхэлдэг байжээ. Монгол эрдэмтэд манж, төвд болон бусад хэл дээр бүтээлээ туурвиж, гадаад оронд, голдуу төвдөд очиж ном хаялцан эрдмийн зэрэг хамгаалж байсан байна. Шашны зан үйлийн хурал номын ажил эрхэлдэг, эрдмийн цол олгодоггүй дацангууд нь шашны эрдмийн ямар нэгэн мяндаг зэрэг олгодоггүй боловч шашны чиглэлээр сургалт явуулдаг байв. Гэвш цол хамгаалаад Буддын гүн ухаан заах эрхтэй болдог байсан. Энэ нь Буддын гүн ухааны сургалтын тогтолцоо нь нарийн дэг жаягтай байсныг харуулж байна. Бурханы шашны дотоод ухаанаар мэргэшин эрдмийн зэрэг горилж буй лам нар чойрын гүн ухаан, агь тарнийн ухаанд гэсэн хоёр чиглэлд хуваагддаг байсан бөгөөд гавж, лхарамба, дорамба, равжамба нэг түвшний буюу чойрын 5 ботийг судлан гаарамбын дамжааг дүүргэн хүртдэг зэрэг цол юм. Төвдийн Лхаст чойрын 5 ботийг судлан гаарамбын дамжаа барьсан тохиолдолд лхарамба, Төвдийн Ловрон, Дашлүмбэ дацанд гаарамбын дамжаа барьсан тохиолдолд дорамба, Төвдийн Гүмбөн дацанд чойрын гүн ухаанд суралцан дамжаа барьсан лам равжамба хүртдэг байна. Харин агь тарнийн чиглэлээр жүд дацанд суралцан дүүргэж агримба цол хүртдэг ажээ.

НОМ ЗҮЙ

Архивын баримт

МУУТА. ФМ-85, д-1, хн-347

НАХ-Байгууллагын тусгай архив. ДЯЯ. Ф-1-3-4, хн-164

Ном

Банзрагч, Ч., Сайнхүү, Б. (2004). Монголын хүрээ хийдийн түүх. Улаанбаатар.

Богд Зонхава. (2003). Бодь мөрийн зэрэг. Улаанбаатар.

Бэгз, Н. (2011). Монголын боловсрол судлалын шинэ парадигм. Улаанбаатар.

Гантуяа, П. (2015). XVI-XX зууны Монголын сүм хийд эрдэмт мэргэд. Улаанбаатар.

Дагвадорж, О. (2004). Уламжлалт боловсролын тогтолцоонд Монгол дацангийн гүйцэтгэсэн үүрэг. Улаанбаатар.

Диваасамбуу, Г., Тайвансайхан, Д. (2005). Монголын Бурхан шашны түүхэн тойм. Улаанбаатар.

- Зава Дамдин Лувсандаян. (2014). Их Монгол оронд Бурханы шашин дэлгэрсэн түүх Алтан дэвтэр”
- МБШИС Дармадалаа. (1995). Их Монголын оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч цагаан лянхуан эрхис хэмээх оршвой. Улаанбаатар.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар. Монгол соёлын өв олон улсын нийгэмлэг. Монголын урлагийн зөвлөл. (2009). Монголын сүм хийдийн товчоон. Улаанбаатар.
- Лувсанцэрэн, Г., Ариунаа, Э. 2014. *Буддын уламжлалт мэдлэг ухааны үндэс*. Улаанбаатар.
- Samuel, B., Sherab, C.(1993). *An introduction to the Buddha and histeachings*. New York.